


ВИРУСТ ХЕПАТИТААС СЭРГИЙЛЭХ: ҮҮНИЙГ МЭД

Дэлхий дээр **400** сая хүн вирус хепатитийн халдвартай амьдарч байна.



Монгол Улс В,С вирус хепатитийн халдвар өндөр тархсан орны нэг.

Элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын **80%** вирус хепатитийн гаралтай байна.

Хепатитийн С вирус нь Хүний Дархлал Хомсдолын Вирус /ХДХВ/ -ээс **10** дахин, хепатитийн В вирус нь ХДХВ -ээс **100** дахин илүү халдварлах чадвартай байна.


ХҮН БҮР ВИРУСТ ХЕПАТИТИЙН ХАЛДВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ

ВИРУСТ ХЕПАТИТААС СЭРГИЙЛЭХ: ТАНИАС ШАЛТГААЛНА


Та вирус хепатитийн халдвар дамжих замуудыг мэдсэнээр халдвараас сэргийлж чадна.



Шинжилгээгүй цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх



Зүү тариурыг дамжуулан хэрэглэх



Халдвартай хүний цус, биологийн шингэнээр бохирлогдсон эмнэлгийн багаж хэрэгсэл



Шүдний сойз, сахлын татуургыг бусадтай дамжуулан хэрэглэх




Төрөх үед халдвартай эхээс урагт



Хамгаалалтгүй бэлгийн хавьталд орох


ДАРХЛААЖУУЛАЛТ:

Хепатитийн В вирусийн эсрэг вакцин хийлгэснээр халдвараас урьдчилан сэргийлэх боломжтой. Харин хепатитийн С вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх вакцин хараахан гараагүй байна.



ОНОШИЛГОО:

Хепатитийн вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ нь хурдан бөгөөд энгийн.



ЭМЧИЛГЭЭ:

С вирус хепатитийн шинэ эмийн эмчилгээ нь 90 - 95% - ийн үр дүнтэй байна. В вирус хепатитийн халдвар бүрэн эдгэрэхгүй ч эмчлэгдэх боломжтой.

